



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/159

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн өмчит зарим байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, сэргээн засварлаж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон, акталж данс бүртгэлээс хасуулах санал ирүүлсэн тээврийн хэрэгслийн байдалтай газар дээр нь танилцаж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2.Акталж данс бүртгэлээс хасуулах хүсэлт ирүүлсэн тээврийн хэрэгслийн талаар холбогдох санал, дүгнэлт боловсруулж 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Х.Гантулга)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзоригт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110200839

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 13 өдрийн
А/159 дугаар захирамжийн
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Х.Гантулга	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Ү.Ганболд	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	В.Оюумаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга
	Б.Энхжин	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	П.Хадбаатар	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Э.Болор-эрдэнэ	Нийслэлийн Төр захиргааны Авто бааз УТҮГ-ын дарга
	Т.Бадамдагий	Нийслэлийн Төр захиргааны Авто бааз УТҮГ-ын Эдийн засагч, нягтлан бодогч
	А.Чойжилсүрэн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Тээвэр, логистикийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
	Ц.Нанжид	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хөрөнгө хариуцсан ахлах зохион байгуулагч
	Ж.Мөнхжаргал	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Аж ахуйн ажилтан
Нарийн бичгийн дарга:	М.Энхболд	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн Менежментийн хэлтсийн дарга